



Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй гэж заасан. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1961 онд баталсан Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 1971 онд баталсан Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, 1988 онд баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцод Монгол Улс нэгдэн орсон¹ бөгөөд үндэсний хууль тогтоомжоо эдгээр конвенцод нийцүүлэх үүргийг хүлээсэн.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.3.4-т “...мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна” гэж, 3.4.4.3-т “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлнэ” гэж тус тус заажээ.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2-т “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн бөгөөд уг зорилтын хүрээнд 2021-2030 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

а/“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.8-д “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын

¹Монгол Улс Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцид 1999 онд, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцод 2003 онд тус тус нэгдэн орсон.

хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ” гэж, 2.2.9-д “Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах ...” гэж;

б/мөн уг арга хэмжээний 2.2.35-д “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна” гэж, 7.3.6-д “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна” гэж;

в/түүнчлэн уг арга хэмжээний 7.3.9-д “... мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг бий болгон, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлнэ” гэж, 7.3.13-т “Тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд болон хилийн боомтыг хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг илрүүлэх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, түүхий эд (перкурсор)-д хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц, нохойн сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно” гэж тус тус заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.1.9-д “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүхий л үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх, мансуурах донтой хүнд олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж заасан.

Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар тусгасан байна.

1.2.Практик шаардлага

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль анх 2002 онд батлагдсан бөгөөд тус хууль нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилготойгоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших 24 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил, түүнд холбогдогчийн тоо жил бүр өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль батлагдах үед буюу 2002 онд цагдаагийн байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой

холбоотой гэмт хэрэг 2 бүртгэгдэж байсан бол 2014 онд 62, 2015 онд 79, 2016 онд 98, 2017 онд 222, 2018 онд 200, 2019 онд 258, 2020 онд 204, 2021 онд 187, 2022 онд 230, 2023 онд 238, 2024 онд 254, 2025 онд 307 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

Харин энэ төрлийн зөрчлийн тухайд 2017 онд 48, 2018 онд 122, 2019 онд 227, 2020 онд 207, 2021 онд 216, 2022 онд 265, 2023 онд 228, 2024 онд 311, 2025 онд 394 зөрчил тус тус цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна. 2025 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоог өмнөх оныхтой харьцуулахад гэмт хэрэг 20 гаруй хувиар, зөрчил 26,6 хувиар тус тус өсжээ.

2017–2025 оны хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт 2,422 хүн холбогдсон байна. Насны ангиллаар авч үзвэл, холбогдогчдын 4.4 хувийг 13–17 насны өсвөр насныхан, 50.4 хувийг 18–25 насны залуучууд, 35.8 хувийг 26–35 насныхан, 9.2 хувийг 36 ба түүнээс дээш насныхан эзэлж байна.

Боловсролын түвшний хувьд холбогдогчдын 1 хувийг бага ангийн хүүхэд, 11.4 хувийг бүрэн бус дунд боловсролтой, 60.5 хувийг бүрэн дунд боловсролтой, 4.3 хувийг тусгай дунд боловсролтой, 22.2 хувийг дээд боловсролтой иргэд эзэлж байна.

Нийгмийн байдлын хувьд дээрх холбогдогчдын 59.5 хувийг ажилгүй, 18.7 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 8.9 хувийг оюутан, 7.8 хувийг хувийн хэвшлийн ажилтан, 2.6 хувийг сурагч, 0,9 хувийг төрийн бус байгууллагын ажилтан, 0,7 хувийг төрийн албан хаагч, 0,08 хувийг орон гэргүй, 0,04 хувийг хорих ял эдэлж буй иргэд эзэлж байна.

Харин 2017-2025 онд зөрчлийн хэрэгт нийт 1976 хүн холбогдсон бөгөөд үүний 20,9 хувийг 13-17 насны хүүхдүүд, 50,6 хувийг 18-25 насны, 21,6 хувийг 18-35 насны залуучууд тус тус эзэлсэн бол 6.8 хувийг 36-аас дээш насны иргэд эзэлжээ.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэргийн улмаас гадаад улсад Монгол Улсын 47 иргэн хорих ял эдэлж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 30 иргэн ял эдэлж байгаагаас Бээжин хотод 3, Хөх хотод 21, Хонконгт 6 хүн тус тус хоригдож байна. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсад 6, Бүгд Найрамдах Турк Улсад 5, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2, Малайз Улсад 2, Япон Улсад 1, Камбож Улсад 1 иргэн хорих ял эдэлж байна.

Ялын хэмжээний хувьд 1 иргэн бүх насаар хорих ял шийтгүүлсэн бол 25-аас дээш жилийн хорих ялаар 4, 20–25 жилийн хорих ялаар 5, 10–19 жилийн хорих ялаар 18, 1–9 жилийн хорих ялаар 5 хүн тус тус шийтгүүлжээ. Харин 15 иргэний хувьд хорих ялын хугацаа тодорхойгүй байна. Эдгээр тоон мэдээллээс үзэхэд гадаадын улс орнуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт ялын хатуу бодлого баримталж буй нь харагдаж байна.

Харин Монгол Улсад сүүлийн 7 жилд гадаад улсын 12 иргэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт шалгагдсанаас Холбооны Бүгд Найрамдах Нигери Улсын нэг, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нэг иргэн хорих ялаар тус тус шийтгүүлжээ.

2006–2010 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн дийлэнх хувийг дотоодод ургадаг мансууруулах үйлчилгээтэй олсны ургамалтай холбоотой гэмт хэрэг эзэлж байсан бол 2011 оноос эхлэн энэ төрлийн гэмт хэргийн шинж, өөрчлөгдөж, химийн аргаар боловсруулсан мансууруулах болон сэтгэцэд нөлөөт синтетик бодисын хэрэглээ нэмэгдэх хандлага ажиглагдах болсон.

Түүнчлэн зарим төрлийн эм, эмийн бэлдмэлийг зориулалтын бусаар, урвуулан хэрэглэж мансуурах тохиолдол өсөж, үүний улмаас иргэд эрүүл мэндээрээ хохирох, цаашлаад амь насаа алдах эрсдэл бий болж байна.

Тухайлбал, 2017-2025 онд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсний улмаас 26, энгийн эм /Тебантин/-ийг мансуурах зорилгоор урвуулан хэрэглэсний улмаас 11, мөн ахуйн хэрэглээний газ хэрэглэж мансуурсны улмаас 12, нийт 49 хүн нас барсан тохиолдол бүртгэгджээ.

Сүүлийн 8 жилийн хугацаанд нийт 17 төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт болон урвуулан хэрэглэх эрсдэлтэй эм, бодис буюу каннабис 587 кг, гашиш 9,379 гр, мөс 12,511 гр, экстази 247 ширхэг, JWH-018 (ADB-Butanica) 840 мл, CBD-OIL 376 мл, THC агууламжтай чихэр 61 ширхэг, LSD 1328 ширхэг, DXM 1,059 гр, 146 ширхэг, Мими 11,050 гр, тебантин эм 7091 ширхэг, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм 3,631 ширхэг, 261 гр, efetrin hidroklorur 500 гр, героин 200 гр, DHG 10 ширхэг, pinasa 15 мл хураагдсан байна. Үүнийг мансууруулах үйлчлэлийн хүн/тунгаар илэрхийлбэл ойролцоогоор 419,293 хүн/тунтай тэнцэхээр байна.

Дээрх тоо баримт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилтыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн зохицуулалт хангаж чадахгүй байгааг харуулж байна. Цаашлаад энэ сөрөг үзэгдэл нь үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, соёлын үнэт зүйлсийн дархлаанд системийн түвшний эрсдэл үүсгэж болзошгүй байгааг анхаарах шаардлагатай юм.

2. Сүүлийн жилүүдэд лабораторийн аргаар боловсруулсан, олон улсын гэрээ, конвенцод тусгагдаагүй шинэ төрлийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисууд олон улсын хэмжээнд болон манай улсад бүртгэгдэх тохиолдол ихсэж байна. Эдгээр бодис нь химийн найрлага, бүтэц, үйлчилгээний хувьд байнга хувьсан өөрчлөгдөж, нэр төрөл нь тасралтгүй олширсоор байна.

Манай улсын хувьд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт тодорхой хэмжээнд бүрдсэн хэдий ч, нийгмийн хэрэгцээ шаардлага, шинээр үүсэж буй гэмт хэргийн нөхцөл байдалд бүрэн нийцэхгүй, хэрэгжилт, үр нөлөө хангалтгүй байна. Түүнчлэн, олон улсын гэрээ, конвенцоор баталсан жагсаалтад багтаагүй, лабораторийн аргаар боловсруулсан, химийн бүтэц нь өөрчлөгдсөн шинэ төрлийн бодисыг хууль бусаар эргэлтэд оруулсан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэлгүй байгаа нь практик байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл үүсгэж, гэм буруутай этгээд ял завших боломж, нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд манай улс мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисын үндэсний жагсаалтыг баталж, олон улсын гэрээнд тусгагдаагүй боловч мансууруулах, сэтгэцэд нөлөөт үйлчилгээ үзүүлэх, хамаарал үүсгэх, эрүүл мэнд, амь насанд эрсдэлтэй эм, бодисыг уг жагсаалтад хамруулан ангилж, тэдгээрийн ангилалд суурилан энэ төрлийн эм, бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, хориглох, хязгаарлах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Дэлхийн улс орон, бүс нутгуудад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисын хууль бус хэрэглээ өсөн нэмэгдэж буйтай уялдан тэдгээрийг бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, зуучлах, борлуулахтай холбоотой зохион байгуулалттай сүлжээ улам тэлж, үйл ажиллагааны хэлбэр нь илүү нарийсаж байна.

Түүнчлэн химийн гаралтай шинэ төрлийн синтетик бодисын тархалт нэмэгдэж байгаа нөхцөлд олон улсын худалдаа, дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээ, хэрэглэгч, түүний дотор эцсийн хэрэглэгчийн бүтэц, бодисын тоо хэмжээ, хөдөлгөөний талаарх мэдээлэлд суурилсан хяналтын механизмыг боловсронгуй болгох, холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт, журмын уялдаа холбоог сайжруулах, олон улсын хяналтад байдаг болон хяналтад ороогүй бодисуудыг хууль бус эргэлтэд орохоос урьдчилан сэргийлэх шаардлагатайг Олон улсын мансууруулах бодисын хяналтын зөвлөл (INCB)-өөс зөвлөсөн.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг” конвенцод энэ төрлийн бодисын хууль бус үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг зарим бодис, түүний дотор прекурсор буюу түүхий эд, химийн урвалж, уусгагч болон исэлдүүлэгчид тавих хяналтын арга хэмжээ шаардлагатайг заасан.

Манай улс тус конвенцод заасан 29 төрлийн угтвар бодисыг хууль, журмын дагуу эрдэм шинжилгээ, судалгаа, шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлд голчлон ашигладаг. Угтвар бодис нь химийн бодист хамаарах тул Монгол Улсад угтвар бодистой холбогдох харилцааг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар зохицуулж байна.

Химийн бодис ашиглахад хуульд заасны дагуу зөвшөөрөл авах шаардлагатай боловч практикт химийн бодис хэрэглэж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулах, бүртгэл, судалгаа хангалтгүй хөтлөх, мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт сул, хүний нөөцийн чадавх дутмаг байх зэрэг зөрчил нийтлэг байна. Үүний улмаас төрийн хяналт, бүртгэл, тайлагналын нэгдсэн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, химийн бодисын эргэлтэд үр нөлөөтэй хяналт тавих боломж хязгаарлагдаж, улмаар гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх нөхцөл бүрдэж байна.

Ийм нөхцөлд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг гарган авахад ашиглагдах химийн бодисын шинж чанар, зориулалт, эрсдэлийн талаар мэргэжлийн болон олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тэдгээрийн учруулж болзошгүй хор аюулыг бодитоор үнэлэх, хууль ёсны эргэлтийг хамгаалах, байгууллага, иргэдийн аюулгүй ажиллагааг хангах, хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх бодлогын болон зохион байгуулалтын арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

3.Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1988 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг” конвенц²-д Монгол Улс 2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр нэгдэн орсон. Тус конвенцод мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын “хууль бус эргэлт” гэдгийг тодорхойлж, үүнтэй холбоотой зохицуулалтыг дотоодын хууль тогтоомждоо тусгахыг үүрэг болгосон байдаг.

Үүнтэй холбоотойгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын “хууль ёсны эргэлт”-ийг хуульчлан тодорхойлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих шаардлагатай юм. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг “хууль ёсны эргэлт”-ээс гадуур эргэлтэд оруулсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэхээр хууль тогтоомжид тусгаж, олон улсын гэрээнд заасан үүргээ биелүүлэх нь зүйтэй байна.

Манай улсын хувьд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодисын хууль ёсны эргэлтийг тодорхой зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй буюу

² Төрийн мэдээлэл, Тусгай дугаар IV боть, МУ-ын ОУ-ын гэрээ, УБ, 2006, 1005 дахь тал, <https://legalinfo.mn/mn/detail/1239>.

мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль ёсны эргэлтэд оруулах процессыг хуульд нарийвчлан тодорхойлоогүй байгааг анхаарч, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодисын эргэлтийг зөвхөн зөвшөөрлийн үндсэн дээр, төрийн холбогдох байгууллага бүртгэж, төрийн хяналт дор явуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгох шаардлагатай болжээ.

Үүнтэй холбоотойгоор мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох дундын мэдээллийн нэгдсэн цахим санг бий болох, үүгээр дамжуулан төрийн байгууллага хооронд мэдээллийг шуурхай солилцож, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, шаардлагатай арга хэмжээ авах, бодлого боловсруулахад ашиглах боломжийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар мансуурах донтох эмгэгтэй этгээд сайн дурын үндсэн дээр эмчлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд ердийн журмаар эмчилгээ, үйлчилгээ авах, харин донтох эмгэг нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэхээр зохицуулсан байна.

Гэсэн хэдий ч, хэрэгжилтийн түвшинд мансуурах донтох эмгэгтэй этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилсэн тохиолдол бүртгэгдээгүй байгаа нь уг зохицуулалт практикт хэрэгжихгүй, хэлбэрийн шинжтэй байгааг илтгэж байна. Энэ нь донтох эмгэгийг эрүүгийн болон захиргааны хариуцлагын хүрээнд авч үзэх хандлага давамгайлж, эмчилгээ, сэргээн засах, нийгэмшүүлэх чиглэл дутмаг байгааг харуулж байна.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий этгээд эмчилгээ авах зорилгоор эмч, мэргэжилтэнд хандсан тохиолдолд гэмт хэрэг, зөрчилд шалгагдах эрсдэл үүсэхийн зэрэгцээ эмч нь хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах үүрэг болон үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах мэргэжлийн үүргийн хооронд эрх зүйн зөрчилтэй нөхцөлд ажиллах байдал бий болж байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд мансууруулах бодист донтсон хүнийг хэвтүүлэн эмчлэх ор 35, өдрийн эмчилгээний ор 25 байдаг хэдий ч эмчлүүлэгсдийн тоо харьцангуй цөөн байдаг.³

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий этгээдэд доод тал нь 3–6 сарын хугацаанд, зарим тохиолдолд олон жилийн турш үргэлжлэх эмчилгээ, сэргээн засах үйлчилгээ шаардлагатай бөгөөд эмчилгээний дараах шатанд тухайн хүний гэр бүл, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал зэрэг анхдагч хэрэгцээтэй уялдсан дэмжлэг, нийгэмшүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэхгүй тохиолдолд дахин хэрэглэх, улмаар эмчилгээний үр дүн алдагдах өндөр эрсдэлтэйг мэргэжлийн байгууллагууд онцолдог.

Иймд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий хүнийг эмчлэх, сэргээн засах, нийгэмшүүлэх үйл ажиллагааг салангид бус, харин эрүүл мэнд, хууль сахиулах, нийгмийн хамгаалал, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг салбаруудын уялдаа холбоонд тулгуурласан, олон талт, цогц, тогтвортой тогтолцооны хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн болон институцийн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

³ Мансууруулах эс, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ХЗҮХ, 2023 он

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүн согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураараа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулна" гэж, 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албадан эмчлэх эмнэлэг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяалалд ажиллана" гэж, мөн зүйлийн 11.4-т "Албадан эмчлэх эмнэлэг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байх ба түүнийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэрийг Засгийн газар гаргана" гэж тус тус заасан.

Тус заалтын хэрэгжилтийн нөхцөл байдлыг авч үзвэл, согтуурсан, мансуурах донтох эмгэгтэй хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх газрын чиг үүргийг Төв аймгийн Баян сумд байршилтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Төмөр замын Мааньт өртөөн дэх Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар хэрэгжүүлж байна. Хууль хэрэгжсэнээс хойш 2025 оны байдлаар тус газарт мансууруулах донтой этгээдийг албадан эмчилсэн тохиолдол бүртгэгдээгүй ба зөвхөн архины хамааралтай хүмүүст албадан эмчилгээ хийж байна⁴.

Түүнчлэн гэм буруутай нь тогтоогдсон бөгөөд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий хүнд мөн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Харин цагдан хоригдох явцад цөөн тооны сэжигтэн, яллагдагчийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд эмчлүүлж байжээ⁵.

Эндээс дүгнэж үзэхэд, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан "Мансуурах донтой нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилнэ" гэсэн зохицуулалт огт хэрэгжээгүй байна.

Иймд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, түүнчлэн хамаарал бүхий этгээдэд үзүүлэх сайн дурын болон албадан эмчилгээний эрх зүйн зохицуулалтыг оновчтой, үр нөлөөтэй болгож, тэдгээрт үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нийгмийн хамгааллын дэмжлэгийг уялдаа холбоотой, шат дараалсан байдлаар хэрэгжүүлэх тогтолцоо, эрх бүхий байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн зааг, хамтын ажиллагааны механизмыг тодорхой болгох шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ гэмт хэрэг, зөрчил илрүүлэх үйл ажиллагаанаас ангид, өөрийн санаачилгаар оношлуулж, эмчлүүлэхээр хандсан этгээдийг сайн дурын үндсэн дээр эмчилгээ, сэргээн засах үйлчилгээнд хамруулах эрх зүйн баталгааг бүрдүүлж, түүнийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэнтэй нь холбогдуулан эрүүгийн болон захиргааны журмаар эрх зүйн байдлыг нь дордуулахгүй байх хамгаалалтын зохицуулалтыг хуульчлан тогтоох нь зүйтэй юм.

⁴ Мансууруулах эс, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ХЗҮХ, 2023 он, Төв аймгийн Баян сумын "Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын" холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс

⁵ Мансууруулах эс, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ХЗҮХ, 2023 он, ШШГЕГ-ын эмнэлгийн холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсгээс

Мөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамаарал бүхий хүн нь бусад хэлбэрийн донтолттой хүмүүстэй нэг дор эмчлэгдэж байгаа тохиолдолд бусад хэлбэрийн донтолттой хүнийг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглэгч болгоход уруу татаж, энэ төрлийн бодисын хэрэглэгчийн тоо өсгөх эрсдэлтэй байдгийг мөн анхаарах шаардлагатай юм.

5.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гишүүн улс бүр мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүний хор уршгийг арилгах чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг идэвхтэй зохион байгуулах шаардлагатайг сануулж, энэ чиглэлийн ажлаа эрчимжүүлэхийг зөвлөсөн. Мөн тус албанаас 2010 онд гаргасан тайланд Монгол Улсыг “дамжин өнгөрүүлэгч улс” гэж дүгнэж байсан бол 2014 оны тайланд “хэрэглэгч улс” болсон тухай дурджээ.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус наймаа нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцод заасанчлан үндэстэн дамнасан, нарийн зохион байгуулалттай, нууц, далд аргаар үйлдэгддэг гэмт хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх арга, зохион байгуулалт боловсронгуй болж, үндэсний аюулгүй байдалд аюул, занал учруулах шинжтэй болж байна.

Иймд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийг Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ болох Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Мансууруулах эмийн тухай” 1961 оны нэгдсэн конвенц, “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” 1971 оны конвенц, “Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” 1988 оны конвенцуудад нийцүүлэх шаардлагатай байна.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тухайн бодисын төрөл, хэмжээ, үйлдлийн хор уршиг болон бусад объектив талыг харгалзан зөрчил, гэмт хэргийн шинжийг нарийвчлан зааглаж, хүлээлгэх хариуцлага, ял шийтгэлийн бодлогыг ялгамжтай болгох шаардлагатай байна.

Ийнхүү хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн зохицуулалт нь цаг үеийн өөрчлөлт, шинэ төрлийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын тархалтын хандлагад нийцэхгүй, бодит нөхцөл байдлаас хоцорсон шинжтэй байгаагаас гадна энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн тоо жилээс жилд өссөөр байгаа нь эрх зүйн орчны үр нөлөө хангалтгүй байгааг илтгэж байна.

Түүнчлэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисын хор хөнөөлийг иргэдэд таниулах, хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, хамаарал бүхий этгээдийг эмчлэх, мансууруулах үйлчилгээтэй ургамлыг устгах зэрэг зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээний эрх зүйн үндэс, зохион байгуулалтын механизм тодорхой бус хэвээр байна. Үүнээс энэ төрлийн эм, бодисын “хууль ёсны эргэлт”-ийн ойлголт, хамрах хүрээг бүрэн тодорхойлоогүй, нэгдсэн бүртгэл, хяналтын тогтолцоо бүрдээгүй, үндэсний жагсаалт батлагдаагүй зэрэг нь хууль бус эргэлт, хор уршгаас урьдчилан сэргийлэх, үр нөлөөтэй тэмцэх боломжийг хязгаарлах эрсдэлийг бий болгож байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагыг харгалзан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах, хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг таниулах арга хэмжээ, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралт байдалд орсон хүнд эрүүл мэнд, сэргээн засах, нийгмийн хамгааллын цогц тусламж үйлчилгээ үзүүлэх, хэрэглэсэн хүнд хор

хөнөөлийг таниулах, дахин хэрэглэхгүй байхад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ явуулах, эдгээр бүх үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын оролцоо, чиг үүргийг тодорхой болгох, уялдуулах, хууль бусаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эргэлтэд оруулсан үйлдлүүдэд хүлээлгэх хариуцлага, ялын бодлогыг оновчтой болгох зорилгоор тус хуулийн төслийг боловсруулна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна гэж заасан бөгөөд тус хуулийн төслөөр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн бүтэц, уялдаа өөрчлөгдөж, мөн тус хуулийн 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох тул төслийг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ нэртэйгээр боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

1/нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомж, хуулийн нэр томьёоны тодорхойлолт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд баримтлах зарчмын тухай;

2/ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай, нэн түрүүнд санхүүжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай;

3/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын дотоодын жагсаалт, ангиллын тухай;

4/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд төрөөс тавих хяналт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хуульд зааснаас бусад тохиолдолд эргэлтэд оруулахыг хориглох тухай болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах зориулалтын тухай;

5/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага, зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах зохицуулалт, зөвшөөрлийг шилжүүлэхийг хориглох, зөвшөөрлийг хүчингүй болгох, зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайлан болон тайланг хадгалах зохицуулалт;

6/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эм, эмийн түүхий эд, эмийн үйлчлэх бодис үйлдвэрлэх, хилээр нэвтрүүлэх, тээвэрлэх, худалдах, олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эмээр үйлчлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар түүх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг гүйцэтгэх, мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах, улсын нөөц, зэвсэгт хүчинд эмчилгээний зориулалтаар ашиглах, мөн эрх бүхий байгууллага эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, шинжилгээний зорилгоор ашиглах зохицуулалт, улмаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хадгалах, тээвэрлэх, устгахад тавих шаардлага болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал устгах зохицуулалт;

7/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн байгууллагын тогтолцоо, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний хороо, хууль зүй, дотоод хэрэг, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөө аж ахуй, гадаад харилцаа,

боловсрол зэрэг холбогдох бусад асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн тухай;

8/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ, хамаарал бүхий байдлыг сайн дурын шинжилгээний үндсэн дээр эрт илрүүлж сайн дурын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах тухай;

9/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ, нийгмийн хамгааллын нөхөн сэргээх арга хэмжээ, эмчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай;

10/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн цахим сан, сангийн төрөл, түүнд оруулах мэдээллийн тухай;

11/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд дахин хэрэглэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх болон олон нийтэд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг таниулах, хор уршгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээний тухай;

12/мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлаас урьдчилан сэргийлэх, хууль бусаар эргэлтэд оруулахтай тэмцэх талаар хүн, хуулийн этгээдийн үүрэг, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг зохицуулах, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны эрх зүйн орчин боловсронгуй болж, нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах эерэг үр дагавар үүснэ. Үүнд:

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих чиглэлээр төрөөс баримтлах бодлого, түүний зорилт, хэрэгжүүлэх үндсэн зарчим тодорхой болно. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдал хангагдаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийт, ялангуяа хүүхэд, залуучуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар таниулах эрх зүйн орчин боловсронгуй болно;

2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүх үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх журмыг хуульд тодорхой тусган, үйл ажиллагаа явуулах нөхцөл, шаардлагыг тодорхой болгоно;

3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий хүнд олон улсын арга зүйн дагуу эрүүл мэнд, сэтгэц-нийгэм, нийгэм хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, донтолтыг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, мансуурах донтой этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах зохицуулалт бий болно;

4.Нийтийн эрүүл мэндийг хамгаалах, мансуурах донг эмчлэх шинэ арга, ажиллагааны талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж нэмэгдэнэ;

5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих арга хэмжээг оновчтой зохион байгуулах, үр дүнг үнэлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээнд тогтмол судалгаа, мониторинг хийх мэдээллийн нэгдсэн цахим сан бий болно;

6.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис импортлох, худалдах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зэргээр эргэлтэд оруулж байгаа байгууллагуудын хүлээн авсан, зарцуулсан, худалдан борлуулсан, устгасан бодис, эм, бэлдмэлийн тоо, хэмжээ, зориулалт зэргийг бүртгэлд оруулах, хяналт тавих, тайлагнах журам хуульчлагдана;

7.Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг оновчтой болгох, үүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл, хэмжээ, үйлдлийн хор уршиг болон бусад объектив талыг харгалзан гэмт хэргийн шинжийг хийдэлгүй, тодорхой, оновчтойгоор тодорхойлж, ял шийтгэлийн бодлогыг Эрүүгийн хуульд заасан “Шударга ёсны зарчим”-ыг хангаж тодорхойлно;

8.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, тэдгээрийг таслан зогсоох ажилд ахиц, дэвшил гарах төдийгүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх иргэдийн мэдлэг дээшилж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан хууль хоорондын уялдааг хангах зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын төрийн ордны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

----oOo----